



79

**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/44

Номгон

Сум (хот)-ын төвөөс малыг албадан
гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн 7.7.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, аймгийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/483 дугаар захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор Баянхонгор сумын нутаг дэвсгэр дэх ойн зурваст газрууд, ногоон байгууламжийг хамгаалж сум (хот)-ын төвд тэжээж буй малыг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 31-ний өдрийн хооронд албадан гаргасугай.

2. Мал албадан гаргах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

С.Батцэрэн

(Засаг даргын Орлогч)

Гишүүд:

Т.Отгонбаатар

(Баянхонгор-тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар)

Багийн Засаг дарга нар

Байгаль орчны тасаг

Мал эмнэлгийн тасаг

Хөдөө аж ахуйн тасаг

Идэвхтэн байгаль хамгаалагч нар

Гудамж, хороолол хариуцсан идэвхтэн нар

Нарын бичгийн дарга:

Ж.Дэлгэрмаа

(Байгаль орчны тасгийн дарга, Байгаль орчны

Захирамж 2023

621010889

асуудал хариуцсан мэргэжилтэн)

3.Хотын төвд мал маллаж байгаа иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудад албан мэдэгдэл хүргүүлэн, албадан гаргах ажлыг хариуцлагатай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

4.Мал албадан гаргахад болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллахыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, Цагдаагийн дэд хурандаа (Б.Мөнгөнтулга), Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Ж.Дэлгэрмаа) нарт даалгасугай.

5.Хотын төвөөс малаа гаргаагүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцож, арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Ж.Дэлгэрмаа)-д үүрэг болгосугай.

6.Хотын төв, ойн зурваст газрууд, ногоон байгууламж, хязгаарласан бүсийн орчимд байгаа малд эрүүл мэндийн үзлэг шинжилгээ хийж, мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Ө.Цэвээнбат)-д үүрэг болгосугай.

7.Малыг албадан гаргах мэдээллийг иргэд, олон нийтэд мэдээлэх ажилд хариуцлагатай хандаж ажиллахыг Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан ажилтан (Д.Отгонтунгалаг)-д үүрэг болгосугай.

8.Ажлын явц үр дүнг тухай бүр сумын Засаг даргад танилцуулахыг Байгаль орчны ажлын алба, Хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлгийн тасгийн дарга нарт үүрэг болгосугай.

9.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Хүрэлсүх)-д даалгасугай

ДАРГА



Г.ЭНХБАЯР